

**БАГАНУУРЫН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
(БАРИХ- АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ) КОНЦЕССЫН
ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ - 2**

2021 оны 05 сарын 14 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү "Багануурын цахилгаан станц" төслийг хэрэгжүүлэх (барих-ашиглах- шилжүүлэх) концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ (Цаашид "Нэмэлт гэрээ" гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт, Концессын гэрээний 3-р зүйлийн 3.8.1 дэх хэсэг, төслийн концессын гэрээний 3 дугаар зүйлийн 3.8.1 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2019 оны А/3049 дугаар, 2020 оны А/3541 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, 2019 оны ВРР-2019-045, ВРР-2019-052, 2020 оны ВРР-2020-041 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн

Нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн Худалдан авах ажиллагааны газар /цаашид "Эрх бүхий этгээд" гэх/-ын дарга Х.УЛАМ-ӨРНӨХ,

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Багануур Пауэр" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал WANG, SHOUNE /цаашид "Концесс эзэмшигч" гэх/ нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.0. Төрийн худалдан авах ажиллагааны газар нь Үндэсний хөгжлийн газрын өмнө нь Багануурын цахилгаан станцын төсөлтэй холбоотой эрхэлж байсан ажлын чиг үүрэг, бүх үүрэг, хариуцлагыг, түүний дотор Концессын гэрээний бүх үүрэг, хариуцлагыг бүрэн хүлээнэ.

1.1. "Багануурын цахилгаан станц" төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.62 дахь заалтыг " **"Цахилгаан станц"** гэж концессын "Барих-ашиглах- шилжүүлэх" төрлөөр Багануур дүүрэгт баригдах 1-р




шатны 2х200МВт болон 2-р шатны 300МВт-ын нүүрсээр ажиллах дулааны цахилгаан станцыг хэлнэ. 1-р шатны 2х200МВт-ыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу хэрэгжүүлнэ. 2-р шатны суурилагдсан хүчин чадлын шийдлийг Монгол Улсын эрчим хүчний хөгжлийн төлөвлөгөө болон цахилгаан эрчим хүчний зах зээлийн хэрэгцээг үндэслэн Монгол Улсын Засгийн газар нь концесс эзэмшигчтэй тухайн үед нь харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Цахилгаан станцын бүрдэл хэсэгт цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам болон холбогдох байгууламжуудыг агуулна." гэж өөрчлөн найруулав.

1.2. Төслийн концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.69-д "“Итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэж концессын гэрээний Хавсралт 10-ын дагуу батлагдсан Хяналтын гэрээг концесс олгогчийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэхээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон “эрчим хүчний барилга байгууламжийн барилга угсралтын ажилд техникийн хяналт тавих, зураг төсөлд магадлал хийх эрх бүхий байгууллага (гэрээ байгуулах үед “Эрчим хүчний хөгжлийн төв”-ийг)” болон “төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг тус тус ойлгоно.” гэсэн заалт нэмэв.

1.3. Төслийн концессын гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.5-д ‘Концессын гэрээнд заасан концессын эрх болон нөхцлүүд цахилгаан станцын төслийн 1 болон 2 дугаар шатанд ижил хүчинтэй үйлчилнэ. Цахилгаан станцын 2-р шатны суурилагдсан хүчин чадлын шийдэл (блокуудын тоо, хүчин чадлыг хамтад нь оруулах) болон барилгын үе шатны ажлын хуваарийг 1-р шатны барилгын ажил бүрэн дуусгавар болсны дараа Монгол Улсын Засгийн газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт нэмэв.

1.4. Төслийн концессын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2.1.13-т “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх явцад гадаадаас ажиллах хүч зайлшгүй ажиллуулах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлагатай ажиллах хүчний асуудлыг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх бөгөөд станцыг ашиглалтад хүлээн авсны дараа Монгол Улсын Засгийн газраас баталсан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг мөрдөнө.” гэсэн заалт нэмэв.

1.5. Төслийн концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.68 дахь заалтыг ““Нэрлэсэн данс” гэж Концессын төлбөрийн хувьд Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсоор нэрлэн заасан дансыг, Хяналтын гэрээний төлбөрийн хувьд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Регистрийн дугаар 5790719, Голомт банкин дахь ам.долларын



2105012732, төгрөгийн 2105010095 тоот дансыг тус тус хэлнэ." гэж өөрчлөн найруулав.


ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Гэрээний талуудыг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд төслийн концессын гэрээний салшгүй хэсэг байж, хуулийн адил хүчинтэй байна.

2.2. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ нь Монгол, англи хэл дээр 4 хувь үйлдэгдэх бөгөөд талууд тус бүр 2 хувийг хадгална. Монгол, англи хувилбарт ойлголтын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбарыг баримтална.

НЭМЭЛТ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:


Х.УЛАМ-ӨРНӨХ



“БАГАНУУР ПАУЭР” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:


ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ
QIAO, HONGYONG

